



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Онгон сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СБА-2022/14/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Баруун-Урт
2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 99029193
Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Даваа
Утас: 99035990
Цахим хаяг: davaag@audit.gov.mn
Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК
Захирал: А.Сарангэрэл
Утас: 9988 4842
Цахим хаяг: gereltekhburtgelaudit03@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Төлбөрийн акт.....	16
4.2 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 100

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ОНГОН
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Э.ХИШИГТ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онгон сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онгон сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,229,181.46</u>	<u>146,019,144.46</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,123,902.23
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	1,123,902.23
3121	Төгрөг	-	1,123,902.23
31211	Төрийн сангийн харилцах	-	43,900.23
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	1,080,002.00
33	АВЛАГА	-	98,751,795.00
335	Бусад авлага	-	98,751,795.00
3351	Байгууллагаас авах авлага		98,751,795.00
35	БАРАА МАТЕРИАЛ	27,229,181.46	46,143,447.23
351	Түүхий эд материал	15,192,694.46	20,786,390.23
35110	Тусгай зориулалттай материал	10,517,906.95	10,517,906.95
35130	Эм боох материал	4,674,787.51	10,268,483.28
354	Хангамжийн материал	12,036,487.00	25,357,057.00
35410	Бичиг хэргийн материал	1,229,300.00	2,511,150.00
35420	Аж ахуйн материал	9,222,240.00	11,587,160.00
35460	Хүнсний материал	1,584,947.00	11,258,747.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>674,945,542.59</u>	<u>675,367,306.81</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	674,945,542.59	675,367,306.81
392	Биет хөрөнгө	664,607,542.59	665,029,306.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	497,943,496.00	497,943,496.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(42,174,046.57)	(48,179,224.87)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	101,420,991.00	101,750,991.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(63,475,991.12)	(67,145,991.14)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	315,716,268.79	348,605,017.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	(155,541,242.63)	(178,897,372.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,620,600.00	27,599,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,912,232.76)	(16,651,669.42)
39214	Бусад үндсэн хөрөнгө	147,400.00	147,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(137,700.12)	(142,440.04)
393	Биет бус хөрөнгө	10,338,000.00	10,338,000.00
39301	Програм хангамж	1,070,000.00	1,070,000.00
39303	Хасагдуулга	(1,070,000.00)	(1,070,000.00)
39304	Бусад биет бус хөрөнгө	10,338,000.00	10,338,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>702,174,724.05</u>	<u>821,386,451.27</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>156,385.00</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	156,385.00	-
413	Өглөг	156,385.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	156,385.00	-
4136	Бусад өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>702,018,339.05</u>	<u>821,386,451.27</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	702,018,339.05	821,386,451.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	447,948,271.48	447,948,271.48
51101	Өмч: - төрийн	447,948,271.48	447,948,271.48
512	Хуримтлагдсан үр дүн	54,121,604.10	173,489,716.32
51210	Өмнөх үеийн үр дүн	54,121,604.10	54,121,604.10
51220	Тайлант үеийн үр дүн		119,368,112.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	199,948,463.47	199,948,463.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>702,174,724.05</u>	<u>821,386,451.27</u>

Сүхбаатар аймгийн Онгон сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	783,648,805.00	1,161,206,121.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	121,059,000.00	40,566,371.39
120	Нийтлэг татварын бус орлого	121,059,000.00	40,566,371.39
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	121,059,000.00	40,566,371.39
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	121,059,000.00	40,566,371.39
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	662,589,805.00	411,878,350.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	626,204,500.00	708,761,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	626,204,500.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	708,761,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,319,100.00	262,703,591.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,220,000.00	6,590,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		75,644,131.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	99,100.00	180,469,460.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	46,396,709.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		46,396,709.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	35,066,205.00	102,778,050.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	35,066,205.00	102,778,050.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	615,080,063.61	1,041,838,009.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	615,080,063.61	1,041,838,009.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	614,960,063.61	991,206,409.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	442,745,554.28	561,672,746.90
210101	Үндсэн цалин	281,799,676.73	343,888,488.38
210102	Нэмэгдэл	118,409,915.42	179,303,082.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,737,562.69	7,071,000.00
210104	Урамшуулал	34,798,399.44	31,410,175.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,539,399.60	81,229,809.87
210201	Тэтгэврийн даатгал	42,601,300.00	59,618,365.58
210202	Тэтгэмжийн даатгал	4,484,600.00	5,847,306.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,587,600.00	4,251,684.97
210204	Ажилгүйдлийн даатгал	897,200.00	1,046,539.79
210205	Эрүүл мэндийн даатгал	8,968,699.60	10,465,913.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,475,693.00	42,306,909.00
210301	Гэрэл, цахилгаан	3,555,197.00	4,372,526.00
210302	Түлш, халаалт	36,596,496.00	37,742,383.00
210303	Цэвэр, бохир ус	324,000.00	192,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,665,020.00	45,880,366.00
210401	Бичиг хэрэг	656,665.00	3,366,895.00
210402	Тээвэр, шатахуун	7,909,825.00	26,940,291.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,652,930.00	4,118,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,584,900.00	3,964,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	860,700.00	7,490,180.00
2105	Нормативт зардал	35,056,776.16	207,026,512.83
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,140,705.16	184,924,112.83
210502	Хоол, хүнс	3,916,071.00	19,782,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,320,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	663,500.00	12,495,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		311,000.00
210604	Урсгал засвар	663,500.00	12,184,800.00
2107	Томилолт, зочны зардал	956,000.00	663,400.00
210702	Дотоод албан томилолт	956,000.00	663,400.00

Сүхбаатар аймгийн Онгон сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,822,814.00	1,990,280.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,990,280.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	948,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	513,384.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	23,980.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,138,000.00	
210807	Газрын төлбөр	95,000.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	50,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,035,306.57	37,940,584.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	440,000.00	3,165,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,595,306.57	34,775,484.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	120,000.00	50,631,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	120,000.00	50,631,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	120,000.00	50,631,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	168,568,741.39	119,368,112.22
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	168,568,741.39	119,368,112.22

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/Төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	447,948,271.48	199,948,463.47	-32,943,296.29	614,953,439.66
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	87,064,899.39	-
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	447,948,271.48	199,948,463.47	54,121,604.10	702,018,339.05
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	447,948,271.48	199,948,463.47	54,121,604.10	702,018,339.05
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	447,948,271.48	199,948,463.47	54,121,604.10	702,018,339.05
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	119,368,112.22	119,368,112.22
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	447,948,271.48	199,948,463.47	173,489,716.32	821,386,451.27

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	361,602,955.00	1,022,681,950.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	361,602,955.00	1,022,681,950.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	343,931,700.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	343,931,700.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	708,761,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	99,671,255.00	262,703,591.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	820,000.00	6,590,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		75,644,131.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	99,671,255.00	180,469,460.00

Сүхбаатар аймгийн Онгон сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	46,396,709.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	46,396,709.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	16,752,155.00	4,820,250.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,752,155.00	4,820,250.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>350,075,263.10</u>	<u>1,011,704,547.77</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	350,075,263.10	1,011,704,547.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	349,964,263.10	960,857,447.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	236,309,398.00	561,672,746.90
210101	Үндсэн цалин	154,660,200.00	343,888,488.38
210102	Нэмэгдэл	65,544,998.00	179,303,082.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,395,957.00	7,071,000.00
210104	Урамшуулал	11,708,243.00	31,410,175.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,902,299.60	81,229,809.87
210201	Тэтгэврийн даатгал	20,989,183.00	59,618,365.58
210202	Тэтгэмжийн даатгал	3,673,361.00	5,847,306.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,040,756.00	4,251,684.97
210204	Ажилгүйдлийн даатгал	472,800.00	1,046,539.79
210205	Эрүүл мэндийн даатгал	4,726,199.60	10,465,913.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,331,235.00	42,306,909.00
210301	Гэрэл, цахилгаан	2,465,539.00	9,097,526.00
210302	Түлш, халаалт	24,651,696.00	33,017,383.00
210303	Цэвэр, бохир ус	214,000.00	192,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,566,530.00	48,823,586.00
210401	Бичиг хэрэг	421,415.00	3,654,695.00
210402	Тээвэр, шатахуун	11,300,135.00	26,940,291.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,238,930.00	4,118,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,710,350.00	8,142,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	895,700.00	5,967,750.00
2105	Нормативт зардал	35,207,520.50	208,266,616.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,629,220.50	175,730,781.00
210502	Хоол, хүнс	4,578,300.00	29,445,835.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	3,090,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,019,500.00	10,895,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,535,800.00
210604	Урсгал засвар	1,019,500.00	9,359,800.00
2107	Томилолт, зочны зардал	182,000.00	663,400.00
210702	Дотоод албан томилолт	182,000.00	663,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,843,280.00	3,798,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,798,780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	341,550.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	23,980.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	510,000.00	-
210807	Газрын төлбөр	95,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	618,300.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	602,500.00	3,200,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	602,500.00	3,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	111,000.00	50,847,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	111,000.00	50,847,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	111,000.00	50,847,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>11,527,691.90</u>	<u>10,977,402.23</u>

Сүхбаатар аймгийн Онгон сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		9,853,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		9,853,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		9,853,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(9,853,500.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	11,527,691.00	1,123,902.23
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,527,691.00	1,123,902.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	815,375,740.67	759,934,458.77	55,441,281.90	93.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	815,375,740.67	759,934,458.77	55,441,281.90	93.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	811,975,740.67	757,942,958.77	54,032,781.90	93.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	549,129,900.18	530,913,500.90	18,216,399.28	96.68
210101	Үндсэн цалин	342,558,693.70	313,129,242.38	29,429,451.32	91.41
210102	Нэмэгдэл	154,756,362.28	179,303,082.77	(24,546,720.49)	115.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,969,000.00	7,071,000.00	1,898,000.00	78.84
210104	Урамшуулал	42,845,844.20	31,410,175.75	11,435,668.45	73.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,372,685.49	71,229,809.87	4,142,875.62	94.50
210201	Тэтгэврийн даатгал	53,395,724.41	49,618,365.58	3,777,358.83	92.93
210202	Тэтгэмжийн даатгал	5,957,249.92	5,847,306.30	109,943.62	98.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,296,999.96	4,251,684.97	45,314.99	98.95
210204	Ажилгүйдлийн даатгал	1,065,701.00	1,046,539.79	19,161.21	98.20
210205	Эрүүл мэндийн даатгал	10,657,010.20	10,465,913.23	191,096.97	98.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,502,255.00	42,306,909.00	13,195,346.00	76.23
210301	Гэрэл, цахилгаан	4,833,805.00	9,097,526.00	(4,263,721.00)	188.21
210302	Түлш, халаалт	50,146,450.00	33,017,383.00	17,129,067.00	65.84
210303	Цэвэр, бохир ус	522,000.00	192,000.00	330,000.00	36.78
2104	Хангамж, бараа материалын зардал	43,231,845.00	38,201,050.00	5,030,795.00	88.36
210401	Бичиг хэрэг	2,352,345.00	1,654,890.00	697,455.00	70.35
210402	Тээвэр, шатахуун	27,809,500.00	24,817,560.00	2,991,940.00	89.24
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,112,000.00	4,118,800.00	(6,800.00)	100.17
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,024,250.00	4,642,050.00	(617,800.00)	115.35
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,933,750.00	2,967,750.00	1,966,000.00	60.15
2105	Нормативт зардал	69,427,405.00	59,965,809.00	9,461,596.00	86.37
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	53,731,400.00	48,429,974.00	5,301,426.00	90.13
210502	Хоол, хүнс	12,696,005.00	10,445,835.00	2,250,170.00	82.28
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	1,090,000.00	1,910,000.00	36.33
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,090,650.00	7,484,100.00	1,606,550.00	82.33
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	3,394,300.00	1,605,700.00	67.89
210604	Урсгал засвар	4,090,650.00	4,089,800.00	850.00	99.98
2107	Томилолт, зочны зардал	2,172,000.00	578,000.00	1,594,000.00	26.61
210702	Дотоод албан томилолт	2,172,000.00	578,000.00	1,594,000.00	26.61

Сүхбаатар аймгийн Онгон сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,849,000.00	4,063,780.00	785,220.00	83.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,849,000.00	4,063,780.00	785,220.00	83.81
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,200,000.00	3,200,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,200,000.00	3,200,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,400,000.00	1,991,500.00	1,408,500.00	58.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,400,000.00	1,991,500.00	1,408,500.00	58.57
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,400,000.00	1,991,500.00	1,408,500.00	58.57
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	764,502,500.00	759,978,359.00	55,441,281.90	99.41
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	708,761,400.00	708,761,400.00	-	100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	708,761,400.00	708,761,400.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	55,741,100.00	46,396,709.00	9,344,391.00	83.24
132001	Орон нутгийн төсвөөс	55,741,100.00	46,396,709.00	9,344,391.00	83.24
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	4,820,250.00	(4,820,250.00)	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	4,820,250.00	(4,820,250.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	43,900.23	(43,900.23)	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/Төгрөгөөр/
		Тайлант оны Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	261,623,589.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	261,623,589.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	212,767,989.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,759,246.00
210101	Үндсэн цалин	30,759,246.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,000,000.00
210201	Тэтгэврийн даатгал	10,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,622,536.00
210401	Бичиг хэрэг	1,999,805.00
210402	Тээвэр, шатахуун	2,122,731.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-
2105	Нормативт зардал	148,300,807.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	127,300,807.00
210502	Хоол, хүнс	19,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,000,000.00
210604	Урсгал засвар	6,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	85,400.00
210702	Дотоод албан томилолт	85,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,855,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,855,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,855,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	262,703,591.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	262,703,591.00
	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,590,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	75,644,131.00

	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	180,469,460.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,080,002.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Онгон сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторовын туслах Э.Алтангэрэл, аудиторовын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Онгон сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг, Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 15,408.1 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 12,326.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Онгон сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /мянган төгрөг/ 3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	1,123.9	1,123.9
Авлага	-	98,751.8	98,751.8
Бараа материал	27,229.2	46,143.5	18,914.2
Үндсэн хөрөнгө	674,945.5	675,367.3	421.8
Нийт хөрөнгө	702,174.7	821,386.4	119,211.7
Өр төлбөр	156.4	-	(156.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	702,018.4	837,161.7	135,143.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	702,174.7	821,386.4	119,211.7

Авлага дансны үлдэгдэл 98,751.8 мянган төгрөг болж нэмэгдсэн нь Бишрэлт тун эмийн эргэлийн сангаас авах 794.0 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас санхүүжигдэх Ковид 19 өвчлөлтэй холбоотой эмчилгээ үйлчилгээний зардлын 97,957.8 мянган төгрөгийг авлагаар тусгаснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 46,143.5 мянган төгрөг болж, 18,914.2 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь Ковид 19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн газраас 15,222.6 мянган төгрөгийн вакцин, эмнэлгийн хэрэгсэл, эм бэлдмэл, оношлуур, хамгаалах хувцас хандиваар ирснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 675,367.3 мянган төгрөг болж, 421.8 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн данс Ковид19 цар тахалтай холбоотой хандиваар ирсэн хөрөнгүүдээр нэмэгдсэн байна. Үүнд:

Эрүүл мэндийн газраас 8,837.5 мянган төгрөгийн яаралтай түргэн тусламжийн багц, Ковид-19 цар тахлын эмчилгээнд шаардлагатай машин тоног төхөөрөмжүүд, Эрүүл мэндийн сайдын тушаалаар 12,629.6 мянган төгрөгийн вакцины хэрэгслүүд, Онгон сумын Нутгийн зөвлөлөөс 5,480.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 26,947.1 мянган төгрөгийн хөрөнгө хандиваар ирсэн байна.

Үндсэн хөрөнгийн данс тайлант хугацааны элэгдлийн зардлын 20,603.6 мянган төгрөгийн дүнгээр буурчээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны орлого өмнөх оноос 377,557.3 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас санхүүжигдэх Ковид 19-тэй холбоотой эмчилгээ үйлчилгээний санхүүжилтийг тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрсөн, нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос 261,384.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал өмнөх оноос 426,757.9 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь Ковид-19 тэй холбоотой эм бэлдмэл, нэг хэрэглэдэг хамгаалалтын хувцасны зарцуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 810,762.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 810,762.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 46,260.0 мянган төгрөгөөр бууруулж, 764,502.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 708,761.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 46,396.7 мянган төгрөгийн, НД-ын сангаас 4,820.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 759,934.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлтээр нийт 262,703.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал зардалд 261,623.6 мянган төгрөгийг, улсын төсөвт 1,080.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Төвлөрүүлсэн 1,080.0 мянган төгрөгийг тайлант онд багтаан Сангийн яамнаас буцаан олгосон байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас Ковид-19 өвчлөн хэвтэн эмчлүүлсэн, гэрийн тусгаарлалтад хамрагдсан, дархлаажуулалтанд хамрагдсан өвчтөнүүдийн эмчилгээ үйлчилгээний төлбөрийн 210,969.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Мөн нэмэлт санхүүжилтийн дансанд сорьц тээвэрлэх зардал 85.4 мянган төгрөг, ЭМЯ-наас 32 ажилтанд өгсөн урамшууллын 44,800.0 мянган төгрөг, Баруун урт сумын Эрүүл мэндийн газраас Давсан бадрахын газарт постонд гарсан 2 ажилтны илүү цагийн хөлс 258.7 мянган төгрөг, 150 иргэний хандивласан 6,590.0 мянган төгрөг, нийт 51,734.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг:

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 779,136.3 мянган төгрөгийн 22 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулахаас 767,286.0 мянган төгрөгийн 14 мэдээллийг ил тод байршуулаагүй, 11,850.3 мянган төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн бараа материалын данстай холбоотой 1 алдаа зөрчлийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Онгон сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 783,940.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 4,803.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт, 779,136.3 мянган төгрөгийн шилэн дансны хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгөтэй болон авлагатай холбоотой зөвлөмж өгөв.

4.1 Төлбөрийн акт

1. Байгууллага нь хөдөлмөрийн чадвар алдсаны акттай 2 ажилтны 1-12 дугаар сарын цалингаас ХХОАТ-ыг чөлөөлөлгүй тооцсоноос 2,198.4 мянган төгрөгийг илүү суутгасан.
2. Байгууллага нь хөдөлмөрийн чадвар алдсаны акттай 1 ажилтны цалингаас НДШ-ийг энгийн ажилтны хувиар тооцсоноос НДШ-ийн 434.6 мянган төгрөгийг илүү, ХХОАТ-ыг чөлөөлөлгүй тооцсоноос 1,637.4 мянган төгрөгийг, нийт 2,072.1 мянган төгрөгийг илүү суутгасан.
3. Байгууллага нь хөдөлмөрийн чадвар алдсаны акттай 1 ажилтны 1-5 дугаар сарын цалингаас ХХОАТ-ыг чөлөөлөлгүй тооцсоноос 338,536.12 төгрөгийг илүү суутгасан.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д "Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д "Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө", 22.1.2-т "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого", 25 дугаар зүйлийн 25.3-т "Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3. Байгууллага нь хөдөлмөрийн чадвар алдсаны актын хугацаа нь 2021 оны 6 дугаар сарын 1-нд хугацаа нь дууссан 1 ажилтны 6-12 сарын цалингаас НДШ-ийг энгийн ажилтны хувиар тооцоогүйгээс НДШ-ийг 177,114.08 төгрөгөөр дутуу, ХХОАТ-ыг 17,711.41 төгрөгөөр илүү, нийт 179,133.45 илүү суутгасан.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай 16 дугаар зүйлийн 16.2-т "Хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ", ХХОАТ-ын тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.1-д " Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна", 23 дугаар зүйлийн 23.1-д "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт

дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст 2021 онд нийт 779,136.3 мянган төгрөгийн 22 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 767,286.0 мянган төгрөгийн 14 мэдээллийг ил тод байршуулаагүй, 11,850.3 мянган төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй 121 ширхэг 172,196.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

3. Авлагын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Байгууллага нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас санхүүжигдэх Ковид 19-тэй холбоотой эмчилгээ үйлчилгээний зардлын 97,957.8 мянган төгрөгийг авлага болон орлогоор тусгасан. Уг орлогыг Дээд шатны төсвийн захирагчийн заавраар захиран зарцуулах шаардлагатай байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас санхүүжигдэх Ковид 19-тэй холбоотой эмчилгээ үйлчилгээний зардлын 97,957.8 мянган төгрөгийг Дээд шатны төсвийн

Сүхбаатар аймгийн Онгон сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

захирагчаас зөвшөөрөл авч захиран зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасан "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,,", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Цалинг буруу тооцоолж олгосон	1	4,803.9			1	4,803.9				
2	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	-							1	-
3	Дээд шатны төсвийн захирагчаас зөвшөөрөл авч зарцуулах	1	-							1	-
Дүн		3	4,803.9	-	-	1	4,803.9	-	-	2	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	779,136.3							1	779,136.3
Дүн		1	779,136.3	-	-	-	-	-	-	1	779,136.3
Нийт дүн		4	783,940.2	-	-	1	4,803.9	-	-	3	779,136.3